*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАСГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| **Д/д** | **Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж** | **Шалгуур үзүүлэлт** | **Гүйцэтгэлийн түвшин** | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Биелэлтийн хувь |
| **1** | **2** | **3** | **4** | **5** | **6** | **8** |
| **Зорилт 1.Инновацийг дэмжигч, илтгэл хүлээсэн, ил тод, нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна.** | | | | | | |
| 1.1 | Тоон гарын үсэг олголтыг болон хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах | Хүсэлт гаргасан иргэдэд олгосон тоон гарын үсгийн тоо, хувь | 91,3 | 100 | 1.Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч П.Бужинлхам, улсын бүртгэгч Э.Адъяабаяр нар "Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим шилжилтийн хүрээнд хийж, хэрэгжүүлж байгаа ажил, үйлчилгээ, тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдол" зэрэг цаг үеийн мэдээллээр 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Эрдэнэмандал ахлах сургуулийн ажилтан, алба хаагчдад, 2024 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Баянхонгор аймгийн Хаан банкны салбар, тооцооны төвийн 24 нэгжийн нийт 106 менежер, зээлийн мэргэжилтэн, салбарын захирал, эрхлэгч нарт тус тус сургалтыг орж, тоон гарын үсэгтэй холбоотой гарч буй алдаа, анхаарах зүйлийн талаар харилцан санал солилцлоо.<br>2.Харин тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсгээ хэрэглэж хэвшүүлэхэд чиглэсэн, гар утасны аплейкшнээ ашиглан хэрхэн хэрэглэх, улсын бүртгэлийн хичнээн төрлийн үйлчилгээг **E-Mongolia, E-Business** цахим платформаас тоон гарын үсэг ашиглан төрийн цахим үйлчилгээ авах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга зүйн сургалтыг 20 | 100 хувь |
| | | Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээний тоо | 18 | 40 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | удаагийн арга хэмжээгээр төрийн 20 байгууллагын 200 гаруй албан хаагчдыг сургалтанд хамруулж, тоон гарын үсгийн ач холбогдлыг таниулан сурталчилав.<br>4.Сургуулийн ахлах ангийн сурагчдыг 2024 онд **“Цахим шилжилт-бүртгэлийн цахим үйлчилгээний хөтөч”**-өөр бэлтгэхээр төлөвлөсний дагуу Баянхонгор аймаг дахь Цахим үйлчилгээний хэлтэс, аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран Төрийн цахим үйлчилгээг хэрэглэх, тоон гарын үсгийг хэрэглэх чадварыг сургагч багшаар дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн "Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" бэлтгэх сургалтыг арван жилийн сургуулийн 10-р ангийн хүүхдүүдийг хамруулан 5 сарын 16, 17-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж, сургалтанд хамрагдсан Номундалай, Номгон, Эрдэнэмандал, Эрдэм цогцолбор сургуулийн 10 дугаар ангийн 24 хүүхдийг "Цахим хөтөч-сургагч багш"-аар бэлтгэн сертификатыг 5 дугаар сарын 27-ны өдөр гардуулан өгөв.<br>5."Цахим хөтөч-цахим ур чадварын сургагч багш" нараар дамжуулан төрийн байгууллагуудын цахим үйлчилгээний нэр төрөл, цахим үйлчилгээг **“Тоон гарын үсэг”**-ээр хэрхэн авах, талаарх мэдлэг олгож, мэдээллийг түгээх, цахим сургагч багш нарын хүрээг тэлэх зорилго бүхий сургалтыг 3 удаа зохион байгуулсан ба сургалтанд 10 дугаар ангийн 168, 11 дүгээр ангийн 34 хүүхдүүд хамрагдсан байна.<br>6"Цахим хөтөч" клубыг байгуулж, улмаар клубын суралцагч хүүхдүүдийнхээ ур чадварыг нэмэгдүүлэх ээлжит сургалтыг 3 удаа зохион байгуулсан ба сургалтыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар болон “Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв” УТҮГ хамтран “Цахимд зөв байя” уриатайгаар зохион байгууллаа. Сургалтын хүрээнд Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хиймэл оюун ухааны эерэг болон сөрөг нөлөө, Хувийн мэдээллээ зүй зохистой удирдах, хамгаалах, Цахим ул мөрөө хянах, хамгаалах, Цахим залилангаас урьдчилан сэргийлэх, Эцэг эхийн хяналтын программ, Цахим орчин дахь донтолт, сэтгэл зүйн нөлөөлөл зэрэг сэдвийн хүрээнд мэдлэг олгож, мэдээлэл, зөвлөмжийг өглөө.<br>7.Тайлант хугацаанд 14806 тоон гарын үсэг олгосон байна. | |
| 1.2 | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн байна. | - | 1 | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, төвлөрлийг сааруулах зорилгоор иргэний үнэмлэх дахин авах бүртгэлд өгөгдлийн шинжилгээ хийж, улмаар хэлтэс дээр баталгаажуулдаг байсан бүртгэлийг сумын улсын бүртгэгч нарт шилжүүлсэнээр хугацаа алдах эрсдлийг бууруулж, хэлтэс дээр ажилладаг улсын бүртгэгч нарын ажлын ачааллыг бууруулсан ажил боллоо. | 100 хувь |
| 1.3 | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд өөрчлөх ажлыг үргэлжүүлэн зохион байгуулах | Баянхонгор сумын хилийн цэсийн өөрчлөлтийн дагуу иргэдийн хаяг шинэчлэгдсэн хувь | 70 | 100 | • Хилийн цэсийн дагуу хаяг өөрчлөгдсөн хаягийн өөрчлөлтийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд өөрчлөх ажлын хүрээнд УБЕГ-ын даргад хандан хэлтсийн даргын албан бичгээр 2 удаагийн танилцуулга, хүсэлт илгээсэн.<br>• ИУБГ-ын ахлах мэргэжилтэн н.Наранцэцэг, улсын ахлах бүртгэгч н.Отгон нартай онлайн зүүм ярилцлага хийж, сонгуулийн жил дуусмагц энэ ажилд анхаарал хандуулахаар тогтов.<br>• Баянхонгор сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нартай хилийн цэс өөрчлөлтөөр багаас багт шилжсэн хаягийн дагуу иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгүүлэхэд анхаарах асуудал, багийн оролцоог сайжруулах талаар санал солилцсон "Өглөөний цай" уулзалтыг 2024 оны 05 дугаар | 30 хувьтай |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сарын зохион байгуулав. | |
| 1.4 | Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй иргэний хаягийг хүн бүрээр тулган шалгаж, иргэний байнга оршин суугаа хаягийн бүртгэлийн зөрчилтэй иргэдийн судалгааг баг бүрээр гаргаж, зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | Судалгаа гаргасан тоо | - | Хөдөөгийн 19 сум бүрээр судалгаа гарна | Судалгааг сум бүрээр гаргаж, шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлээгүй иргэдтэй холбоо барьж зөвлөгөө өгөх, шилжилт хөдөлгөөний бүртгэлээ хийлгүүлэхийг уриалах, сумын багийн засаг даргатай хамтран ажиллах талаар улсын бүртгэгч нарт зөвлөмж, чиглэл өгсөн.<br>Судалгаагаар шинэчилсэн хаягаар хаягийн бүртгэлээ хийлгүүлээгүй нийт 1425 иргэн байсан ба үүнээс 375 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлээр зөрчлөө арилгасан байна.<br>**Хэрэгжилтийн шалтгаан:**<br>2024 онд Улсын Их Хурлын болон орон нутгийн сонгуультай холбогдуулан шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуульд заасан үндэслэлээр 2 удаа зогсоосон, мөн 6 суманд газрын даамал байхгүй, байгаа газрын даамлуудын ажлын үр дүнгээс, түүнчлэн иргэдийн өөрсдийн оролцоо, хандлага сулаас шалтгаалан шинэчилсэн хаягаар хаягийн бүртгэлээ шинэчлүүлэх ажил удаашралтай байна. | 30 хувь |
| | | Илэрсэн зөрчлийг арилгасан тоо, хувь | - | 100 хувь зөрчлийг арилгасан байна. | | |
| 1.5 | Бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх | Улсын бүртгэлийн цахим машинаар үзүүлсэн үйлчилгээний тоо | 4500 | 5000 | Улсын бүртгэлийн үйлчилгээг мэдээллийн технологийн арга хэрэгслээр үзүүлэх үйлчилгээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 4G төхөөрөмж 1-ийг нэмж авснаар явуулын үйлчилгээг үзүүлэх боломжоор хангагдсан ба хөдөө сумдад болон зорилтод бүлгийн иргэдэд явуулын үйлчилгээг ... удаа үзүүлж, .... иргэдэд хамрагдсан байна.<br>Хэлтсийн үйлчилгээний зааланд улсын бүртгэлийн киоск машинаас гадна Төрийн цахим үйлчилгээний "E-Mongolia" цахим платформоор үйлчилгээний "ХУРДАН" авах, нөгөө талаар 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн хооронд Хэлтсийн байранд байрласан киоск машинаар тоон гарын үсэг 4504, киоск машинаар иргэний улсын бүртгэлийн ....... лавлагаа олгосон байна. | 100 хувь |
| 1.6 | Улсын бүртгэлийн байгууллагын үйл | Эрх зүйн актын төсөлд санал | 2 | 2 | Улсын бүртгэлийн хуулиуд холбогдох журамтайгаа зөрчилдөж байгаа, мөн практикт | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагаатай холбоотой шинэчлэн боловсруулах шаардлагатай дүрэм, журмын төсөлд саналд хүргүүлэх | хүргүүлсэн тоо | | | хэрэглээнд хэрэгжих боломжгүй байгаатай холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулах, мөн хууль тогтоомжтой нийцүүлж иргэний улсын бүртгэлийн программд нэмэлт хөгжүүлэлт хийх зэрэг 16 төрлийн санлыг хүргүүлсэн байна. | |
| 1.7 | Улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх зорилгоор контент бэлтгэж, түгээх | | - | 5 | Цахим залилан болон улсын бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 5 төрлийн контентыг улсын бүртгэгч П.Эрдэнчимэг, Ж.Оргилмаа, Б.Майцэцэг нар бэлтгэн нийтэд түгээлээ. | 100 хувь |
| 2.1 | Иргэний улсын бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлөх | Бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлтийг шийдвэрлэсэн хувь | 100 | 100 | Тайлангийн хугацаанд хийгдсэн иргэний улсын бүртгэлийн нийт 16765 бүртгэлээс төрсний бүртгэл 1432, гэрлэсний бүртгэл 258, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 63, нас барсны бүртгэл 498, үрчилсний бүртгэл 26, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 71, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчлөлтийн бүртгэл 109, регистрийн дугаар өөрчлөлтийн бүртгэл 6, шинээр олгосон иргэний үнэмлэх 1465, 25, 45 насны сунгалт буюу иргэний үнэмлэхний хугацаа дуусч авсан иргэний үнэмлэх 1983, шилжилт хөдөлгөөний бүртгэл 2380 бүртгэл бүртгэгдсэн байна. | 100 хувь |
| 2.2 | Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл, лавлагаа өгөх | Хүсэлтийг шийдвэрлэсэн хувь | 100 | 100 | Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл, лавлагааны үйлчилгээг 9355 олгосноос иргэн 5669, төрийн болон төрийн бус байгууллагад буюу албан хэрэгцээнд 1752, хууль хяналтын байгууллагад 1934 тус тус олгосон байна. | 100 хувь |
| 2.3 | Төрийн цахим үйлчилгээний портал /E-mongolia/ иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ авах тоог нэмэгдүүлэх | Цахимаар үзүүлсэн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний тоо | 100 | 100 | Мөн шилжилт хөдөлгөөний бүртгэлээс e-mongolia цахим системээр ирсэн 136 хүсэлтийн 58 хүсэлтийг бүртгэж шийдвэрлэсэн бол харин 78 хүсэлтийг татгалзан шийдвэрлэсэн байна.<br><br>e-mongolia цахим системээр дамжуулан улсын бүртгэлийн үйлчилгээ авах бүртгэлийн тоо нэмэгдсэн, бүртгэлийг хэрхэн авах зааварчилгааг сурталчлан таниулах ажлыг “Цахим хөтөч” нараар дамжуулан зохион | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулав. | |
| 2.4 | Иргэний улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх тоог нэмэгдүүлэх | Үзүүлсэн үйлчилгээний тоо | 450 | 900 | Анхан шатны нэгжид болон зорилтод бүлэгт улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд **“Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх өдөрлөг”**-ийг **“Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ”** уриатайгаар сумдын ЗДТГ-ууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгууллаа.<br>• Баянговь сумын Засаг даргын Тамгын газартай хамтран тус суманд 2024 оны 5 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд зохион байгуулж, үндэсний цахим гадаад паспортын 76 бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 24 бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 30 иргэнд эрх зүйн зөвлөгөө өгсөн.<br>• Жаргалант сумын сумын ЗДТГ, 1994 оны төгсөгчид болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нараас бүрдсэн нарийн мэргэжлийн эмч нарын баг, аймгийн Цагдаагийн газартай хамтран "НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ" арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулсан ба төрсний бүртгэл 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд 3, лавлагаа 3, гадаад паспорт 49, нийт 57 бүртгэл, давхардсан тоогоор 56 иргэнд зөвлөгөө өгөв.<br>• Жинст, Богд сумдын ЗДТГ-тай хамтран суманд нь улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба 108 гаруй иргэдэд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв.<br>• Улсын бүртгэгч томилогдоогүй Хүрээмарал сумын иргэдэд 2024 оны 1 сарын 2-12-ныг хүртэлх өдрүүдэд зохион байгуулж, 14 | 100 хувь |
| | | Зорилтод бүлэгт үзүүлсэн үйлчилгээний тоо | 10 | 10 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | иргэнд тоон гарын үсэг олгож, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 4, төрсний бүртгэл 3, эцэг тогтоолтын бүртгэл 1, иргэний үнэмлэхний дахин 5, нийт 27 бүртгэл бүртгэсэн байна.<br>• Эрдэнэцогт сумын ЗДТГ-тай хамтран Баянхонгор сумын Шаргалжуут 8 багийн /алслагдсан аймгийн төвөөс 60 гаруй км зайтай/ иргэдэд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба үүнд 50 гаруй иргэдэд бүртгэлийн үйлчилгээ авсан байна.<br>**1.2. Зорилтод бүлгийн иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:**<br>• Хөгжлийн бэрхшээлтэй 4 иргэний иргэний үнэмлэх дахин авах, шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгүүлэх хүсэлтийн дагуу гэрээр нь очиж иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, бичиг баримттай болгов.<br>• Мөн ажлын цагаар ажлаасаа гарч чадахгүйн улмаас төрийн үйлчилгээ авч чаддаггүй сургууль, цэцэрлэг, цагдаа, цэргийн байгууллагуудын албан хаагч нарт газар дээр нь очиж улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх ажлыг 2024 оны 05-р сараас эхлэн зохион байгуулсан ба нийт 25 байгууллагад албан бичиг хүргүүлэн, тухайн байгууллагын өөрсдийн захиалсан өдөр цагт нь тохируулан хуваарь гарган, хуваарийн дагуу 3,4,5 дугаар цэцэрлэг, Цагдаагийн газар, 2, 4-р 10 жил зэрэг нийт 6 байгууллагад улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь очиж үзүүлж, тоон гарын үсэг олголт 20, гадаад паспортын бүртгэл 19, иргэний үнэмлэхний дахин 1, нийт 40 бүртгэл хийгдсэн байна. | |
| 2.5 | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг “Бямба гаригт” төлөвлөгөө гаргах хэрэгжүүлэх | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 100 | Ажлын өдрүүдээр улсын бүртгэлийн үйлчилгээгээ бүрэн авч дуусаагүй байгаа болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан “**Төрийн үйлчилгээ иргэд ойрхон**” уриатай “**Бямба гариг**” төлөвлөгөөт ажлыг 2024 оны 09 | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сараас эхлүүлэн 7 хоног бүрийн хагас "Бямба" гаригт өглөөний 11 цагаас 16 цаг хүртэлх хугацаанд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн ба энэ хугацаанд иргэний улсын бүртгэлийн 82 удаагийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. | |
| 3.1 | Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн мэдээллийн зөрчлийг арилгах | Бүртгэлийн зөрчил арилгуулахаар иргэдээс ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэсэн хувь | 87,7 | 100 | **Нөхөн бүртгэлийн талаар**<br>Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн жагсаалтад Баянхонгор аймгийн нэгжид хамаарах нийт 79 бүртгэлээс Төрсний бүртгэл 31, гэрлэсний бүртгэл 22, эцэг эх тогтоосны бүртгэл 1, гэрлэсний бүртгэл 22, ИУБ-16 3, бүртгэл бүртгэсэн байна. Эдгээр бүртгэлийг нэг бүрчлэн дахин шалгахад алдаатай, зөрүүтэйгээр оруулсан гэх бүртгэл бүртгэгдээгүй байна.<br>**Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн талаар**<br>Дээр дурьдагдсан жагсаалтад нэмэлт өөрчлөлтийн нийт 402 бүртгэл бүртгэгдсэн байгаагаас төрсний бүртгэл 283, эцэг эх тогтоосны бүртгэл 69, үрчилсний бүртгэл 17, гэрлэсний бүртгэл 1, овог нэр өөрчилсний бүртгэл 32, нас барсны бүртгэл 21 байна. Бүртгэл тус бүрийг шалгасан тайланг, тайлбарын хамт 2024 оны 10 дугаар сарын 23-нд Иргэний улсын бүртгэлийн газарт ariunzaya@burtgel.gov.mn хаягаар илгээж тайлагнав. | 100 хувь |
| 3.2 | "Нас барсан" төлөвтэй иргэдийн мэдээллийг цахим санд шалгах, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авах | Шалгасан бүртгэлийн тоо, хувь | - | 100 | "Нас барсан" төлөвтэй иргэдийн мэдэллийг иргэний улсын бүртгэлийн цахим санд шалгах ажлыг хуваарь гарган улсын бүртгэгч нараас шүүлгэж, шалгасан мэдээллийг дахин нягтлан үзэж, зөрчлийг арилгав. Тайланг b.otgon@burtgel.gov.mn хаягаар тайлагнасан | 100 хувь |
| 3.3 | Иргэний улсын бүртгэлийн Мэдээлэл лавлах системд нэмж цахимжуулсан баримтуудыг иргэний улсын бүртгэлийн цахим сангийн мэдээлэлтэй тулган шалгах, илэрсэн | 2007-2013 он хүртэлх төрсний бүртгэл –ХААТР-11, үрчилсний бүртгэл ХААТР-12, эцэг /эх/ тогтоолтын бүртгэл-ХААТР-14 эх нотлох баримтыг иргэний | - | 100 | Иргэний улсын бүртгэлийн "Мэдээлэл лавлах" системд цахимжаагүй байгаа хаатр, маягтыг бэрэн цахимжуулж архивын баяжилтыг хийх, нөгөө талаас архивын ажлын ачааллыг бууруулах зорилгоор 2007-2021 онуудад төрсөн иргэдийн ХААТР-11, ХААТР-13, ХААТР-14 маягтуудыг цахимжуулах ажлыг 2024 оны 03 сараас эхлүүлсэн ба тайлант хугацаанд | 80 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | зөрчлийг арилгах арга хэмжээг авах | улсын бүртгэлийн цахим сангийн мэдээлэлтэй тулган шалгасан тоо, илэрсэн зөрчлийг арилгасан тоо | | | Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Богд, Галуут, Баян-өндөр, Баян-овоо, Гурванбулаг, Баянбулаг, Заг, Өлзийт, Эрдэнэцогт, Хүрээмарал, Бууцагаан, Баянговь, Баянлиг, Жинст зэрэг 17 сум бүрэн цахимжуулж дууссан, харин Жаргалант сум 2007-2010 он, Шинэжинст сум 2017-2021, Баянхонгор сум 2015-2021 онуудын маягтуудыг цахимжуулж дуусаагүй байна.<br>Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цхаим санд төрсөн болон үрчилсний бүртгэлийн мэдээллийн талбар алдаатай орсон мэдээллийг засах ажлыг зэрэгцүүлсэн ба 2007-2009 онд төрсөн 89 иргэний төрсний бүртгэлийн мэдээллийг 8 иргэний үрчилсний бүртгэлийн мэдээллийг нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр засаж, зөрчлийг арилгасан байна. | |
| | | 2013-2021 он хүртэлх төрсний бүртгэл –ХААТР-11, үрчилсний бүртгэл ХААТР-12, эцэг /эх/ тогтоолтын бүртгэл-ХААТР-14 эх нотлох баримтыг иргэний улсын бүртгэлийн цахим сангийн мэдээлэлтэй тулган шалгасан тоо, илэрсэн зөрчлийг арилгасан тоо | - | 100 | | |
| | | 1963-1970 оны гэрлэлтийн бүртгэлийг эх нотлох баримт болон цахим сангийн мэдээлэлтэй тулган шалгасан тоо, илэрсэн зөрчлийг арилгасан тоо | - | 100 | **2.1.1.** Мөн Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны ХААТР-15-ыг цахимжуулах, иргэний улсын бүртгэлийн цахим санд бүртгэгдээгүй гэрлэлтийн бүртгэлийн маягтуудыг нөхөн цахимжуулах ажлыг тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 оны 2, 3 сард багтаан хийхээр төлөвлөсөн байсан боловч сонгуулийн ажилтай холбогдуулан хугацааг хойшлуулсан байсан ба 12 сардаа багтаан дуусгахаар улсын бүртгэгч нарын ажлын хуваариалан хуваарийн дагуу ажиллаж байна.<br>Иргэний улсын бүртгэлийн цахим санд 1963-1998 оны гэрлэсний 63 бүртгэл, гэрлэлт дуусгавар болсны 3 бүртгэлийг нөхөн бүртгэж, хяналтын улсын байцаагчийн 2 удаагийн дүгнэлтээр гэрлэсний бүртгэлийн 2 зөрчлийг, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1 зөрчлийг тус тус арилгав. | 100 хувь |
| | | 1970-1998 оны гэрлэлтийн бүртгэл эх нотлох баримт болон цахим сангийн мэдээлэлтэй тулган шалгасан тоо, илэрсэн зөрчлийг арилгасан тоо | - | 100 | | 100 хувь |
| 3.4 | Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны | Зөвлөмж хүргүүлсэн тоо | 2 | 4 | • Иргэний улсын бүртгэлийн газраас | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрсдлийг бууруулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | Сургалт болон нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан тоо | 2 | 4 | иргүүлсэн чиглэл, зөвлөмж бүрийг цаг тухайд нь улсын бүртгэгч нартаа дамжуулан мэдээллэж, арга зүйгээр хангаан ажиллаж байна. Мөн төрсний бүртгэлийг бүртгэхдээ нэрийн толийг бүрэн дүүрэн ашиглаж байх, нэрийг сонгохдоо нэрийн галигийг давхар харж хянаж байж нэрийг сонгох талаар өдөр тутамдаа зөвлөгөө өгч, гарсан алдаа бүрийг даруй засуулж баталгаажилтыг хийж байна.<br>• Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудлын талаар хяналтын улсын байцаагчтай хамтран аргазүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан, мөн албан бичгээр 2 удаа чиглэл, хэлтсийн ажилтнуудын хаалттай facebook группээр 4 удаагийн чиглэлийг өгч, мэргэжил арга зүйгээр хангаж, арга зүйн туслалцаа үзүүлэв.<br>• Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, бүртгэлийн эх нотлох баримтыг үнэлэх, хуулийг зөв ойлгож хэрэглэх чиглэлээр улсын бүртгэгч нарт танхимын нэгдсэн сургалтыг 2 удаа хийсэн.<br>Иргэний улсын бүртгэлийн дугаар эсхүл, регистрийн дугаараар бүртгэл хөтөлсөн тухай тэмдэглэлийг тогтмол хөтөлж, уг тэмдэглэлийг 7 хоног бүрийн 5 дахь өдөр улсын ахлах бүртгэгчид мэдээллэж байх үүргийг өгсөн ба тэмдэглэлийн мэдээллийг сар бүр авч нэгтгэн ИУБГ-т 12 удаа танилцуулсан байна. | |
| 3.5 | ИУБГ-аас иргүүлсэн зөрчлийн мэдээлэл, түүнийг шийдвэрлэх | ИУБГ-аас иргүүлсэн зөрчлийн мэдээллийн тоо | | 100 | Иргэний бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчлийг шийдвэрлэсэн хувь | 100 | 100 | санд нэгээс дээш бүртгэгдсэн, эсхүл бүртгэлийн аль нэг талбарын мэдээлэл зөрүүтэй, бүртгэлийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, нас барсан газар зэрэг мэдээлэл нь зөрүүтэй өөрийн нэгжид харъяалах 237 бичвэрийг шалгахтай холбоотой "Нас барсны бүртгэл шалгах тухай" Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 3/12305 дугаарт албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган тайланг Илтгэх хуудсаар тайлагнав. | |
| 4.1 | Иргэний улсын бүртгэлийн баримтыг цахимжуулах | Иргэний баримтын архивын тодорхойгүй төлөвт байгаа эх нотлох баримтыг цахимжуулсан хувийн хэргийн тоо | Архивын тодорхойгүй төлөвт байгаа ...... баримт байна. | Архивын тодорхойгүй төлөвт байгаа ...... баримтын 30 хувь | Архивын тодорхойгүй төлөвт байгаа баримтын 30 хувийг цахимжуулсан болно. | 30 хувь |
| 4.2 | Улсын бүртгэлийн нэгжид хөтлөгдсөн иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулах | Хийсэн бүртгэлийн тоогоор иргэний улсын бүртгэлийн эх нотлох баримтыг цахимжуулсан хувь | 24623 хуудас цахимжуулсан /100 хувь | 100 | Тайлант хугацаанд Иргэний улсын бүртгэлийн 11 төрлийн 20452 үйлчилгээг үзүүлсэн байх бөгөөд бүртгэлийн эх нотлох баримт болох 39440 хуудас баримтыг цахимжуулсан байна. | 100 хувь |
| 4.3 | Иргэний улсын бүртгэлийн Мэдээлэл лавлах системд цахимжаагүй 2007-2021 оны төрсний бүртгэл-ХААТР-11, үрчилсний бүртгэл-ХААТР-12, эцэг /эх/ тогтоосны бүртгэл-ХААТР-14 маягтыг цахимжуулах | 2007-2013 он хүртэлх төрсний бүртгэл –ХААТР-11, үрчилсний бүртгэл ХААТР-12, эцэг /эх/ тогтоолтын бүртгэл-ХААТР-14 эх нотлох баримтыг цахимжуулсан тоо | - | 100 | Иргэний улсын бүртгэлийн "Мэдээлэл лавлах" системд цахимжаагүй байгаа нэг талаас цахим архивын баяжилтыг хийх, нөгөө талаас архивын ажлын ачааллыг бууруулах зорилгоор 2007-2021 онуудад төрсөн иргэдийн ХААТР-11, ХААТР-13, ХААТР-14 маягтуудыг цахимжуулах ажлыг 2024 оны 12 сараас эхлүүлсэн ба өнөөдрийн байдлаар Баацагаан, Баянцагаан, Бөмбөгөр, Богд, Галуут, Баян-өндөр, Баян-овоо, Гурванбулаг, Баянбулаг, Заг, Өлзийт, Эрдэнэцогт, Хүрээмарал, Бууцагаан, Баянговь, Баянлиг, Жинст зэрэг 17 сум бүрэн цахимжуулж дууссан, харин Жаргалант сум 2007-2010 он, Шинэжинст сум 2017-2021, Баянхонгор сум 2007-2012 онуудын маягтуудыг цахимжуулж дуусаад байна. Үлдсэн маягтуудыг 12 сардаа | 80 хувь |
| | | 2013-2021 он хүртэлх төрсний бүртгэл –ХААТР-11, үрчилсний бүртгэл ХААТР-12, эцэг /эх/ тогтоолтын бүртгэл-ХААТР-14 эх нотлох | - | 100 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | баримтыг цахимжуулах | | | багтаан цахимжуулж дуусахаар төлөвлөсөн болно. | |
| 4.4 | Иргэний улсын бүртгэлийн Мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны гэрлэлтийн бүртгэл ХААТР-15 маягтыг цахимжуулах | 1963-1970 оны гэрлэлтийн бүртгэл–ХААТР-15 маягтыг цахимжуулсан тоо | - | 100 | Мөн Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны ХААТР-15-ыг цахимжуулах, иргэний улсын бүртгэлийн цахим санд бүртгэгдээгүй гэрлэлтийн бүртгэлийн маягтуудыг нөхөн цахимжуулах ажлыг тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2024 оны 2, 3 сард багтаан хийхээр төлөвлөсөн байсан болович сонгуулийн ажилтай холбогдуулан хугацааг хойшлуулсан байсан ба 12 сардаа багтаан дуусгахаар улсын бүртгэгч нарын ажлын хуваариалан хуваарийн дагуу ажиллаж байна. | 100 хувь |
| | | 1970-1998 оны гэрлэлтийн бүртгэл-ХААТР-15 маягтыг цахимжуулсан тоо | - | 100 | | |
| 5.1 | УБЕГ болон хэлтсээс зохион байгуулж буй танхим, цахим сургалтанд иргэний улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах | Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо | 23 | 23 | УБЕГ-аас зохион байгуулсан "Авлига ашиг сонирхол, ашиг сонирхоын зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх", "Улсын бүртгэлийн зөрчил, эрсдлээс урьдчилан сэргийлэх" "зэрэг 6 удаагийн зорилтод сургалтанд улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулав.<br>Хэлтсээс зохион байгуулсан 12 удаагийн сургалтанд сумдын улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулж, оролцоог хангав. | 100 хувь |
| | | Сургалтын тоо | | | | |
| 5.2 | Иргэний улсын бүртгэгч нарын хууль хэрэглэж, эрх зүйн дүгнэлт өгөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулах | Сургалтын тоо | 2 | 3 | Иргэний улсын бүртгэгч нарын хууль хэрэглээний чадварыг сайжруулахад чиглэсэн "Улсын бүртгэлийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, гарч буй эрсдлийг танилцуулж, эрх зүйн дүгнэлт өгөх, мөн иргэний улсын бүртгэлийн төрөл болох үрчлэлт, овог нэр өөрчлөлтийн бүртгэлийн ялгаа, нотлох баримтыг үнэлж, дүгнэлт өгөхөд анхаарах асуудал гэх зэрэг сэдвүүдээр 4 удаагийн сургалт орж, арга зүйгээр хангав. | 100 хувь |
| | | Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо | 22 | 22 | | |
| 5.3 | Иргэний улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагааны эрсдлийг үнэлэх, эрсдлээс сэргийлэх арга барил эзэмших чадавхийг сайжруулахад | Сургалтын тоо | 4 | 4 | УБЕГ-ын даргаас 2024 оны 08 дугаар сарын 21-ий өдөр иргэний улсын бүртгэлд гарч байгаа алдаа, зөрчилд онцгой анхаарч арга хэмжээ авч ажиллах хугацаатай үүрэг даалгаврын хүрээнд ИУБГ-аас Иргэний улсын ахлах бүртгэгч нарт зориулсан 2024 оны 08 дугаар сарын 23-ны | 100 хувь |
| | | Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо | 22 | 22 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | чиглэсэн сургалт зохион байгуулах | | | | өдрийн цахим “Зүүм” сургалтанд оролцож, одоо үүсээд буй гэмт хэргийн шинжтэй бүртгэл хөтөлсөн талаарх мэдээллийг, мөн бүртгэлийн зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх, зөрчилтэй бүртгэл хийхгүй байх талаар мэргэжлийн арга зүйн зөвлөгөө мэдээллийг авч, улсын бүртгэгчдийг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллах үүргийг авлаа.<br>Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудлын талаар хяналтын улсын байцаагчтай хамтран аргазүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан ба хэлтсийн 22 улсын бүртгэгч хамрагдав.<br>Тоон гарын үсэг болоод бичиг баримт ашиглан цахим гэмт хэрэг, залилангийн гэмт хэрэг гарч байгаатай холбогдуулан эдгээр гэмт хэргээс иргэд өөрсдийгөө хэрхэн хамгаалах, урьдчилан сэргийлэх, болгоомжуулсан, анхааруулсан контент бэлтгэх сурталчлах | |
| 5.4 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчилан таниулахад чиглэсэн сургалтыг зохион байгуулах | Сургалтын тоо | 2 | 3 | Сонгуулийн хуулийг сурталчлах таниулах, хуулийн хэрэгжилтийг хангахад иргэдийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зорилтод 5 удаагийн сургалтаас гадна сумдын улсын бүртгэгч нарыг “Сургагч багш”-аар бэлтгэх 16 кридет цагийн сургалтыг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулж, сертификат олгов.<br>Улсын бүртгэгч бүр сумдаа иргэд, байгууллага, сонгуулийн хорооны ажилтнуудад болон улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад сургалтыг тус тус зохион байгуулав. | 100 хувь |
| | | Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо | 22 | 22 | | |
| | | Сумдын Улсын бүртгэгч нар тус сургалтыг хичнээн хүнд түгээсэн тоо | - | 3000 орчим хүнд | | |
| 5.5 | Албан бичиг боловсруулах чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт | Сургалтын тоо<br>Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо | - | 2 багц цагийн сургалт | Иргэний улсын бүртгэгч нарт тайлан болон илтгэх хуудас бичихэд анхаарах асуудал, албан хэрэг хөтлөлтийн стандарт, мөрдөх журмын талаар арга зүйн сургалтыг зохион байгуулсан. | 100 хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих | Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 87.7 | 100 | Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийг зөв болгуулах, цахим санд ороогүй мэдээллийг нөхөн оруулуулах, алдаатай бүртгэлийг засуулах гэх мэт иргэний улсын бүртгэлтэй холбоотой 100 гаруй өргөдөл хүлээн авч, хуулийн хугацаанд нь багтаан шийдвэрлэсэн 65, шийдвэрлэхээр судлагдаж байгаа 35 өргөдөл байна. | 100 хувь |
| 6.2 | УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгаврын бүртгэл хөтөлж, хэрэгжилтийг хангаж ажиллах | Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь | 100 | 100 | УБЕГ-аас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, хугацаатай үүрэг даавлгаврын бүртгэлийг хөтлөх ажлыг улсын бүртгэгч Р.Насанжаргал, З.Дуламсүрэн нарт хариуцуулан өгсөн.<br>УБЕГ-аас ирүүлсэн 6 удаагийн чиглэл зөвлөмжийн дагуу хийж, хэрэгжүүлсэн ажлын тайланг заасан хугацаанд нь багтаан тайлагнаж, хэрэгжилтийг хангаж, ирүүлсэн чиглэл, зөвлөмжийг тухай бүрт нь улсын бүртгэгч нарт зүүм болон фэйж хуудсаар дамжуулан өгч, мэдээллэж, арга зүйгээр хангав. | 100 хувь |
| 6.3 | Иргэний улсын бүртгэлийн мэдээ, тайлан, мэдээллийг холбогдох нэгж, хүнд хүргүүлэх | Хүргүүлсэн тоо | 12 | 12 | • Иргэний улсын бүртгэлийн бүртгэлийн тоон мэдээ, иргэний улсын бүртгэлтэй холбоотой лавлагаа мэдээлэл олгосон бүртгэлийн мэдээ сар бүрийн 27-ны дотор холбогдох нэгж, хүнд хүргүүлсэн байна.<br>• Цаг үеийн үйл ажиллагаатай холбоотой хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, тайлагналтыг заасан хугацаанд нь холбогдох нэгж, хүнд хүргүүлж ..... удаагийн Илтгэх хуудсаар тайлагнасан байна. | 100 хувь |
| 6.4 | Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлан таниулах нийтэд түгээх ажлыг зохион байгуулах | Сурталчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо | 3 | 3 | Иргэний улсын бүртгэлийн тасгаас нийтдээ 32 удаагийн контент, постер бэлтгэж, хэлтсийн фэйж хуудас, сумдуудын фэйж групп, аймгийн "Нээлттэй засаг- Нэг Баянхонгор" фэйж хуудас болонб усад олон нийтийн нээлттэй фэйж хуудсаар дамжуулан түгээсэн байна.<br>Цаг үеийн шуурхай ажлын болон цаг үеийн арга хэмжээний хөтөлбөрийн талаарх 15 удаагийн мэдээг цаг тухай бүрт нь нийтэлж, нийтэд мэдээллэв. | 100 хувь |
| | | Олон нийтэд сурталчилсан мэдээ, мэдээллийн тоо | 5 | 15 | | |
| | | Контент бэлтгэсэн тоо | - | 10 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Улсын бүртгэгч бүрт постер, контент бэлтгэх үүрэг даалгаврыг өгч, бэлтгэн нийтэлсний дүнд улсын бүртгэгч бүр постер, контент бэлтгэх чадварыг эзэмшлээ. | |
| 6.5 | Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх, хууль тогтоомж сурталчлах "Нээлттэй хаалганы" өдөрлөг зохион байгуулах | "Нээлттэй хаалганы" өдөрлөг зохион байгуулсан тоо | 3 | 3 | • "Нээлттэй хаалга" арга хэмжээг Жаргалант, Богд, Жинст, Баянговь, Бууцагаан, Баянбулаг сумуудад зохион байгуулж, иргэдэд иргэний улсын бүртгэлийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэв..<br>• Аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран "Авлигаас ангид төрийн үйлчилгээ" нээлттэй хаалганы өдөр арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хэлтэс дээрээ зохион байгууллаа. Уг арга хэмжээний хүрээнд үйлчилгээ авч буй иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, дүнг албан хаагч нарт танилцуулж, иргэдээс "Талархал" хүртсэн улсын бүртгэгч нарыг хамт олны өмнө сайшааж, анхаарах асуудлын талаар хэлэлцэж, чиглэл зөвлөмж өглөө.<br>• | 100 хувь |
| 6.6 | Аймаг, сумын ИТХ, Засаг дарга, төрийн байгууллагууд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, хамтын ажиллагааг өргөжүүлэх | Санал тавьж шийдвэрлүүлсэн тоо | 1 | 2 | • Цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төв, Парламентын танхимтай хамтран Төрийн цахим үйлчилгээг хэрэглэх, тоон гарын үсгийг хэрэглэх чадварыг сургагч багшаар дамжуулан нэмэгдүүлэхэд чиглэсэн "Цахим хөтөч-сургагч багш" бэлтгэх сургалтыг хамтран зохион байгуулав.<br>• Аймгийн Нотариатын танхимтай хамтран "Шилжилт хөдөлгөөний бүртгэл"-тэй холбогдуулан нотариатаар гэрчлэгдэх үйлдэл баримт бичгийн талаар харилцан зөвлөлдөх уулзалтыг хийж, хууль хэрэглээний талаар нэг мөр ойлголтод хүрч хамтран ажиллав.<br>• ХААН болон Төрийн банктай хамтран Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, гарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар зарим нэг асуудалд зөвшилцөж хамтран ажиллав.<br>• Аймгийн Эрүүл мэндийн газартай | 100 хувь |
| | | Хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 /ХААН банк, Эрүүл мэндийн газар, Цахим үйлчилгээний хэлтэс/ | 7 /ЭМГ, Нэгдсэ эмнэлэг, ХААН, Төрийн банк, Цахим үйлчилгээний хэлтэс, Парламентын танхим, ГХУСАЗЗ / | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамтран Эрүүл мэндийн төвийн дарга, менежер нарт төрсний бүртгэл, гэрлэсний бүртгэлтэй холбоотойгоор эрүүл мэндийн байгууллагаас гаргаж буй алдаа, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга зүйн сургалтыг зохион байгуулав.<br>• Аймгийн Төрийнц ахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран иргэд, олон нийтийнц ахим хэрэглээний ур чадварыг нэмэгдүүлэх, нөлөөллийн ажлын хүрээнд "Цахим элч-цахим сургагч багш"-ийг бэлтгэв. | |
| 6.7 | Иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сурталчлах "Сургагч багш" бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлэх | Сургагч багш бэлтгэсэн тоо | - | 150 | • Иргэний улсын бүртгэлийн цахим үйлчилгээг сурталчлах "Сургагч багш" бэлтгэх сургалтыг 10 жилийн ахлах ангийн хүүхдүүдийг хамруулан 3 удаа зохион байгуулж, "Цахим элч-цахим сургагч багш" сертификатыг олгов.<br>• Сонгуулийн багц хуулийг сурталчлан таниулах, сонгогчийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн нөлөлөлийн ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч нарыг "Сургагч багш"-аар бэлтгэх 16 кридет цагийн сургалтыг 2024 оны 04 дүгээр сард зохион байгуулж, сертификат олгов. | 100 хувь |
| 7.1 | МУИХ-ын 2024 оны ээлжилт сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хангаан ажиллах ажлын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөнйи биелэлтийн хувь | 100 | 100 | • Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн үүрэг, чиглэлийг дагуу хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд заасан Сонгуулийн хэсэг байгуулсан ИТХ-ын тогтоолыг болон сонгуулийн санал авах байрны мэдээллийг шивж оруулах, цахимжуулах, хаягийг тулгах ажлын хүрээнд "Сонгуулийн хэсэг байгуулах" Баянхонгор аймгийн 20 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Сонгуулийн хэсэг байгуулах" тогтоолыг хүлээн авч, хүлээн авсны дараа Иргэний улсын бүртгэлийн газарт бичиг хэргийн E-Dok системээр болон шуудангаар хүргүүлэхийн зэрэгцээ Сумдын ИТХ-ын тогтоолуудыг хүлээн авсан, хүргүүлсэн, election.gazr.mn программд цахимжуулсан зэрэг бүртгэл, мэдээлийг Хэлтсийн даргын 2024 оны | Хэлтэс /ИУБТ/ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 03 дугаар сарын 01-ны өдрийн ... дугаарт албан бичгийн хавсралтаар хүргүүлсэн.<br>• "Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн Сонгогчийн нэрийн жагсаалтад "түр хасав" тэмдэглэгээтэй бүртгэгдсэн иргэдийн мэдээлэл шалгасан тухай" Сонгогчдын нэрийн жагсаалтад **"түр хасав"** тэмдэглэгээтэй сонгогчийн мэдээллийг шалгаж, авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх тайланг Илтгэх хуудсаар тайлагнав.<br>• Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэвлэх ажиллагааг хэлтсийн Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх ажлын хэсэг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч, Иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч нар, мэдээлэл технологийн ажилтан, ахлах нягтлан бодогч, бичиг хэрэг, архивч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр Тагнуулийн Ерөнхий газрын Баянхонгор аймаг дахь хэлтсийн ахлах ажилтан Д.Мөнх-эрдэнийн хяналтын дор хэлтсийн 102 дугаарт тоот өрөөнд 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн өглөөний 09 цаг 30 минутад эхлэж, 15 цаг 40 минутад хэвлэж дуусган, ажлын тайланг ИУБГ-т Илтгэх хуудсаар тайлагнав.<br>Баянхонгор аймгийн Сонгуулийн 104 хэсгийн нийт 56190 сонгогчдын жагсаалтыг 2, 2 хувь хэвлэж актыг бэлтгэн дугтуйлан лацдаж, хүлээлгэн өгөв.<br>УИХ-ын сонгуулийн ажил амжилттай дуусаж, гүйцэтгэлийг бүрэн тайлагнасан болно. | |
| 7.2 | Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжилт сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэхээр заасан чиг үүргийг хангах ажиллах ажлын хүрээнд | Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн хувь | 100 | 100 | • Орон нутгийн сонгуультай холбогдуулан орон нутгийн сонгуулийн хэсэг байгуулсан сумын ИТХ-ын тогтоолуудыг хүлээн авч, журмын дагуу хуулийн хугацанд нь багтаан ИУБГ-т хүргүүлж, сонгуулийн программд цахимжуулж, мэдээллийг оруулах, СНЖ үйлдэх, танилцуулах ажлыг хуульд заасан хугацаанд нь багтаан үйлдэж, | Хэлтэс /ИУБТ/ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэх | | | | танилцуулж, хүргүүлж, сонгуулийн үйл ажиллагааны бүхий л шатанд хийж гүйцэтгэсэн ажлын болон цаг үеийн шуурхай арга хэмжээний тайланг цаг тухай бүрт нь Илтгэх хуудсаар тайлагнаж, алдаагүй, зөрчилгүй ажиллаж, орон нутагт сонгуулийн ажлыг амжилттай зохион байгуулав. | |
| 8.1 | Контент бэлдэж сурах | Контент бэлдэж сурсан байна. | - | 100 | Постер, мэдээ бэлтгэж суралцав.<br>Хэлтсийн фэйж хуудсанд ... мэдээ, постер бэлтгэн нийтэлсэн байна. | 100 хувь |
| 8.2 | Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдана. | Суралцсан кредит цаг | Төрийн удирдлага, Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлагаар Мэргэшүүлэх дипломын сургалтанд хамрагдсан. 2016 оны төгсөгч | Суралцаж төгссөн байна. | 2024 он сонгуулийн жил давхцаж, улмаар иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч сонгуулийн бүхий л цаг үеийн ажлыг ахлан гүйцэтгэх чиг үүргийг гүйцэтгэх чухал хариуцлагатай ажил оногдсонтой холбоотойгоор суралцах цаг боломж гаргаж чадаагүй болно. | 0 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ТАСГИЙН ДАРГА,
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ П.БУЖИНЛХАМ

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч
*(албан тушаалын нэр)*
Пүрэвдагвын Бужинлхамын 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс

Нэгжийн нэр: Иргэний улсын бүртгэлийн тасаг

1. **Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | • Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Инновацийг дэмжигч, итгэл хүлээсэн , ил тод нээлттэй төрийн үйлчилгээний байгууллага байна....... хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. | 54 | 10 | 64 | |
| 2. | Арга хэмжээ 1.2. | 60 | 10 | 70 | |
| 3 | Арга хэмжээ 1.3. | 30 | 10 | 40 | |
| **Зорилт 2. ..........................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. | 54 | 10 | 64 | |
| 2. | Арга хэмжээ 2.2. | 54 | 10 | 64 | |
| 3. | Арга хэмжээ 2.3. | 42 | 10 | 52 | |
| 4. | Арга хэмжээ 2.4. | 42 | 10 | 52 | |
| 5. | Арга хэмжээ 2.5. | 48 | 10 | 58 | |
| 6 | Арга хэмжээ 2.6. | 54 | 10 | 64 | |
| **Зорилт 3. ..........................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. | 42 | 5 | 47 | |
| 2 | Арга хэмжээ 3.2. | 60 | 10 | 70 | |
| 3 | Арга хэмжээ 3.3. | 60 | 10 | 70 | |
| 4 | Арга хэмжээ 3.4. | 60 | 10 | 70 | |
| 5 | Арга хэмжээ 3.5. | 48 | 10 | 58 | |
| 6 | Арга хэмжээ 3.6. | 60 | 10 | 70 | |
| 7 | Арга хэмжээ 3.7. | 60 | 10 | 70 | |
| 8 | Арга хэмжээ 3.8. | 60 | 10 | 70 | |
| **Зорилт 4 ..........................................-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1. | Арга хэмжээ 4.1. | 60 | 10 | 70 | |
| 2 | Арга хэмжээ 4.2. | 60 | 10 | 70 | |
| **Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт** | | | | | |
| 1. | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | | |
| Дундаж оноо: | | | | 62,7 | |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Арга хэмжээ 1. | 90 | 13,5 | |
| 2 | Арга хэмжээ 2. | 70 | 10,5 | |
| 3 | Арга хэмжээ 3. | 50 | 7,5 | |
| Дундаж оноо | | | 10,5 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 3 | |
| 2. | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 4. | Хариуцлагатай байдал | 4 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 3 | |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | | |
| 6. | Мэргэжлийн ур чадвар 1. | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 2. | | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 3. | | |
| Дундаж оноо | | 4.2 | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 6 |
| 2. | Багаар ажиллах | 7 |
| 3. | Харилцаа | 7 |
| Дундаж оноо | | 6.6 |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| | | |

| | | |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)* | *(62,7 оноо)* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(10,5 оноо)* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *( Нэгжийн даргын үнэлгээ )* | *(4.2 оноо)* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *( 6.6 оноо)* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(..... оноо)* |
| **Нийт оноо =** ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | 84 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

...Агентлагийн дарга... ................ /............................/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...2024.12.01...
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

.................................. .............................. /П.Бүтэнмөнхзэм/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

......................
*(огноо)*

***Үнэлгээг хянасан:***
*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

.................................. .............................. /............................/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...2024.12.09...
*(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

.................................. .............................. /Г.Батчир/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

......................
*(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

...Агентлагийн дарга... ................ /............................/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...2024.12.09...
*(огноо)*